**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 01 өдөр　　　Дугаар Б/05　　　Хэрлэн сум

Б.Сүнгээг шилжүүлэн томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны “Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 417 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын хамтарсан 2019 оны 34/31 дугаартай тушаалаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 2.1 дэх хэсэг, “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын шийдвэрээр Мэргэжлийн хяналтын ерөнхий газрыг татан буулгасантай холбогдуулан Хувийн ашиг сонирхлын удирдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл тогтоогдоогүй аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргаар ажиллаж байсан Батсүрэнгийн Сүнгээг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргаар шилжүүлэн томилсугай.

2.Ажил хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

| | | |
|---|---|---|
| Комиссын дарга: | Э.Мөнх-Эрдэнэ | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга |
| Гишүүд: | С.Бат-Эрдэнэ | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн |
| | Д.Уламбаяр | Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Захиргаа хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн |
| | С.Ариунжаргал | Аймгийн Газрын харилцаа, барилга хот |

2.
байгуулалтын газрын Нягтлан бодогч

| | |
|---|---|
| Т.Хосбаяр | Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын архив, албан хэрэг хариуцсан мэргэжилтэн |

3.Б.Сүнгээд аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын албан тушаалын үндсэн цалин, холбогдох нэмэгдлийг тооцож олгохыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

4.Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Б.Сүнгээд үүрэг болгосугай.

5.Б.Сүнгээд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА Ц.ЧОГСОМЖАВ